



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/779

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 4 дүгээр зүйлийн 4.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэрт Буянт голын мөс тэлж, харз гүйсэнээр айл өрхүүдийг усанд автах аюулаас хамгаалах далан байгуулсан ажлын зардалд 5000000 төгрөг /таван сая/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2. Тус арга хэмжээнд зарцуулах 5000000.00 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 онд батлагдсан төсвөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 15-ны өдрийн  
А/779 дүгээр захирамжийн хавсралт



ЖАРГАЛАНТ СУМЫН ЦАМБАГАРАВ БАГИЙН  
АЙЛ ӨРХҮҮДИЙГ УСАНД АВТАХ АЮУЛААС СЭРГИЙЛЭХ  
ДАЛАН БОСГОХ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

№	Хүлээн авах байгууллагын нэр	Хэрэгжүүлсэн ажиллагаа	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт дүн /мянган төгрөг/
1.	Жаргалант сумын ЗДТГ	Нowo, Ковшийн ажлын хөлс /23 машин шороог ачиж буулгах/	23	120000.00	2760000.00
		Шуудайны үнэ /ширхэгээр/	4480	500.00	2240000.00
Нийт дүн					5000000.00

-oOo-